

# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ № 9 (ТОЙМ)

Хуралдаан 2009 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 14.40 цагт эхэлж, 15.40 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 1 цаг 00 минут үргэлжлэв.

<sup>1</sup>	№	Хэлэлцсэн асуудал
1	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын даргын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулсан дүнгийн тухай	Дараагийн хуралдаанаар хэлэлцэхээр хойшлуулав.
2	Засгийн газрын зарим агентлагийн удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг ажлын байран дээр зохион байгуулах тухай	1.Засгийн газрын агентлаг Авто замын газар, Авто тээврийн газар, Төмөр замын газар, Эрүүл мэндийн газар, Эрчим хүчний газрын зэрэг агентлагуудын зарим удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг тус агентлагийн шинэ бүтэц, зохион байгуулалтад шилжихээс өмнө удирдах албан тушаалд ажиллаж байсан бөгөөд уг албан тушаалдаа одоо үргэлжлүүлэн ажиллаж байгаа ажилтнуудаас тухайн ажлын байранд өрсөлдөгчгүйгээр тухайн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь, салбар зөвлөлгүй газрын сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөл зохион байгуулах. 2.Тухайн салбар зөвлөл харъяа агентлагийнхаа дурдсан албан тушаалд ажиллаж байгаа нэр бүхий ажилтнуудын хүрээнд 2009 оны 4 дүгээр сарын 28-ны дотор удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулан, шалгалтын дүнг салбар зөвлөл дээрээ хэлэлцсэн тухай шийдвэрийн хамт энэ оны 5 дугаар сарын 01-ний өдөр ирүүлэхийг даалгав.
3	Төв аймгийн Боловсрол, соёлын газрын даргаар ажиллаж байсан Ч.Цэцгээгийн гаргасан гомдлын талаар Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай	Төв аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь Маргаан хянан шалгах комисс томилж, аймгийн Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлтэй эсэхэд дүгнэлт гаргуулаагүй нь Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйл болон Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, түүнд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 7, 14 дэх заалтыг зөрчсөн байх тул “Дүгнэлт гаргах тухай” Төв аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2009 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 03 тоот тогтоолыг хүчингүй болгосон тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарав.

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

